



# Ай Би хөтөлбөр

CAS эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага

Шинэ Үе Сургууль



### **Ай Би хөтөлбөрийн эрхэм зорилго**

*Ай Би хөтөлбөр нь хүн төрөлхтний өв уламжлал, ёс заншил, хэл соёлыг хүндлэн дээдлэх замаар эх дэлхийнхээ энх тайван байдлыг улам сайн сахих мэдлэг чадвартай, сонирхон судалдаг шинэ залуу үеийг бэлдэхийг эрхэм зорилгоо болгодог. Бид олон улсын байгууллага, засгийн газруудтай хамтран олон улсын жишигт нийцсэн боловсролын хөтөлбөр боловсруулж, чанга хатуу, нягт шалгах үнэлгээний аргачлалыг улам бүр хөгжүүлсээр ирсэн. Энэхүү хөтөлбөрөөр суралцаж буй хүүхэд бүр дэлхийн хаана ч бие даах чадвартай, идэвхитэй, хүсэл тэмүүлэлтэй, хүн бүрийн онцлог чадварыг мэдэрч ойлгож чаддаг насан туршийн боловсролтой иргэн болон төлөвшдөг.*

### **Шинэ Үе сургуулийн эрхэм зорилго**

*Бид шинэ үеийнхэнийг*

*Халамжтай*

*Хариуцлагатай*

*Хүнлэг*

*Хичээнгүй*

*Эрүүл чийрэг*

*Эрдэм боловсролтой*

*Эх хэл өв уламжлалаа хайрлан хамгаалдаг*

*Энэ дэлхийн улс үндэстэн бүрийн ёс заншил ахуй соёлыг хүндлэн дээдлэх иргэн болгож төлөвшүүлнэ.*

IB дипломийн координатор: Т.Ханджав

Утас: +976 9111-7811

Цахим шуудан: [khandjav@shineue.edu.mn](mailto:khandjav@shineue.edu.mn)

Оффис: Шинэ үе сургууль, Сүхбаатар дүүрэг, UNESCO-гийн гудамж-12, өрөө 107

IB CAS координатор: Ө.Оргил

Утас: +976 8989-4580

Цахим шуудан: [orgil@shineue.edu.mn](mailto:orgil@shineue.edu.mn)

Оффис: Шинэ үе сургууль, Сүхбаатар дүүрэг, UNESCO-гийн гудамж-12, өрөө 110

**“Ай Би” программаар суралцагчийн профайлын арван зүйл**

Эх дэлхийгээ амгалан тайван байлгаж, одоо байгаагаас нь илүү сайхан ертөнцийг бий болгохын тулд бид бүгд хүн төрөлхтний нэг хэсэг гэдгээ ойлгосон, энэ дэлхий ертөнцийг хамтдаа хуваалцан хамгаалах ёстой гэдгээ ухамсарласан олон улсын сэтгэхүйтэй хүмүүс болгон хөгжүүлэхэд “Ай Би” программын зорилго оршино. “Ай Би” программаар суралцагчийн профайлын авсан зүйлийг танилцуулж байна.

**СОНИУЧ** Тэд өөрсдийн сониуч зангаа хөгжүүлдэг бөгөөд асуудал (асуулт) ба судалгаа боловсруулан, бие даан суралцах чадвартай байдаг. Мөн идэвхтэй суралцахыг эрхэмлэдэг төдийгүй насан туршдаа суралцаар байдаг.

**МЭДЛЭГТЭЙ** Тэд дотооддоо болон олон улсад ноцтой гэж тооцогдох ойлголт, санаа, асуудлуудыг нээн олж чаддаг. Үүний үр дүнд тэрхүү ойлголт, санаа, асуудлынхаа талаар өргөн болоод тэнцвэртэй ойлголттой болж, гүн гүнзгий мэдлэг олж авч чаддаг.

**СЭТГЭН БОДОГЧ** Тэд ээдрээтэй хэцүү асуудлуудыг таньж мэддэг бөгөөд “creative” буюу сэтгэн бодох чадвараа ашиглан, “critically” буюу маш болгоомжтой шинжилгээ дүгнэлт хийсний үндсэн дээр шийдэлд хүрдэг инициативтай (эхний алхмыг хийж чаддаг санаачилгатай) байдаг.

**ИЛЭРХИЙЛЭГЧ** Тэд мэдээлэл болон шинэлэг санааг нэгээс илүү хэлээр ойлгодог ба харилцан ярианы төрөл бүрийн аргаар “creatively” буюу сэтгэн бодох чадвараа ашиглан, өөртөө итгэлтэйгээр илэрхийлж чаддаг. Мөн хүссэнээрээ бусадтай хамтран баг болж үр дүнтэй ажилладаг.

**ЗАРЧИМЧ** Тэд аливаа үйлдлийг хийхдээ хувь хүн, бүлэг хүмүүс ба нийгмийн бусдад хүлээн зөвшөөрөгдөхийг хүссэн өөртөө итгэлтэй бардам байдлыг нь хүндэлж, тэдэнтэй мэдрэмжтэй, шударга, үнэнч байдлаар харьцдаг. Мөн өөрсдийн үйлдэл болон түүнийг дагалдах үр дагаврын төлөө хариуцлагаа бүрэн хүлээдэг.

**НЭЭЛТТЭЙ СЭТГЭГЧ** Тэд өөрсдийн ёс заншил болон түүхээ ойлгож үнэлэн биширдэг бөгөөд бусад хувь хүн ба олон нийтийн үзэл бодол, үнэт зүйлс ба уламжлалд

нээлттэй ханддаг. Мөн түүнчлэн тэд аливаа зүйлийг олон талаас нь харж, үнэлэлт дүгнэлт хийх чадвартай байдаг төдийгүй өөрийн туршлага дээрээ тулгуурлан өсөн дэвжихийг хүсдэг.

**ХАЛАМЖТАЙ** Тэд бусдын хэрэгцээ болон сэтгэлийг мэдэрч хүндэлдэг, зовлонг нь ойлгож туслахыг хүсдэг ба тэдний нөхцөл байдлыг өөртөө тохиолдсон мэт гүнзгий ойлгож чаддаг. Тэд бусдад үйлчлэхээр тууштай, буцашгүй амлалт өгсөн бөгөөд тэдний үйлдэл нь байгаль орчинд болон бусдын амьдралд эерэг өөрчлөлт үзүүлэхэд чиглэсэн байдаг.

**ЭРСДЭЛ ҮҮРЭГЧ** Тэд танил бус болон тодорхой бус зүйлстэй зоригтойгоор, бүр бодлоготойгоор танилцдаг бөгөөд шинэ үүрэг хариуцлага, шинэ санаа, стратеги (арга, аргачлал) зэргийг бие даан, бусдаас хамааралгүйгээр судалж, туршиж чаддаг. Тэд маш зоригтой ба өөрийн итгэл үнэмшлээ тууштай хамгаалж, өөрийгөө бусдад оновчтой илэрхийлж чаддаг.

**ТЭНЦВЭРТЭЙ** Тэд оюуны ухаан, бие бялдрын ба сэтгэл санааны хөгжлийн тэнцвэртэй байдлыг чухалчилдаг. Энэхүү тэнцвэртэй байдал нь өөрийн болон бусдын сайн сайханд ямар их ач холбогдолтойг ойлгож ухамсарласан байдаг.

**ЭРГЭЦҮҮЛЭГЧ** Тэд өөрсдийн туршлага болон сургалтын талаар нухацтай бодолцдог. Тэд өөрсдийн хувийн хөгжил болон суралцах үйл явцаа сайжруулахын тулд өөрийн хүчтэй давуу талууд ба лимит буюу аль хүртэл явж чадахаа ойлгож, үнэлэх чадвартай байдаг.

## Агуулга

CAS-ын талаар товчхон	5
CAS-ын гурван цөм хэсэг	6
CAS-ын сургалтын долоон үр дүн	8
CAS-ын ажлын үе шатууд	9
Эргэцүүлэл ба Нотолгоо	10
CAS-ын төслүүд	14
Чиглүүлэх асуултууд	15
CAS-ын туршлага болон төслүүдийн жишээ	16
CAS-ын суралцагчийн танилцуулгын хавтас	17
CAS дахь эцэг эхчүүдийн үүрэг	18
Хавсралт 1	19

### CAS-ын талаар товчхон

“...Хэрвээ чи ямарваа нэгэн зүйлд итгэж байвал,

*Бодож, ярьж, бичих бус харин үйлдлээр үзүүл.*” (Петерсон, 2003 он)

“CAS нь дипломын хөтөлбөрийн гол зүрх нь юм. Бага болон дунд боловсролын хөтөлбөрөөс эхлэн сурагчдын гадаад болон дотоод сурах арга барилийг сайжруулан өргөжүүлэхээр CAS нь зориулагдсан. CAS нь creativity, activity and service (доор тайлбарлагдах) гэсэн 3 цөм хэсгээс бүрдэнэ .

- **Creativity** — ямар нэгэн үйл ажиллагаа, шинэ санааг тайлбарлах эсвэл сайжруулах үйл ажиллагаа явуулна

- **Activity** — эрүүл амьдралын хэв маягт зориулан биеийн хүчний үйл ажиллагаа явуулна

- **Service** — бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан тусламжийн үйл ажиллагаа зохиож хамтран ажиллаж, харилцан туслалцах

CAS нь сурагчдад ИВ-ийн суралцагчийн шинж чанарыг бодит болон практик арга замаар харуулах, өвөрмөц бусдаас өөр хувь хүн болж өсч хөгжих, бусадтай харилцаа холбоо үүсгэх үед өөрийн үүргээ ухамсарлах боломжийг олгодог. Сурагчид CAS-аар дамжуулан багийн болон ганцаарчилсан туршилтуудаас мэдлэг чадвар, өөрийгөө болон хүсэл сонирхолоо чөлөөтэй илэрхийлэх чадвар зэргийг эзэмшдэг. (Creativity, activity, service guide, 2017, p.8)

### **CAS-ын гурван цөм хэсэг**

- 1. IB хөтөчид дурьдснаар, CREATIVITY гэдэг нь “урлаг болон бусад эргэцүүлэн бодох сэтгэлгээ шаардсан зүйлс хамрагдана.”**

Таны хүүхэд сонин сэтгүүл бичих, кино хийх, бүжиг дэглэх, жүжигт тоглох эсвэл найруулах, хөгжмийн зэмсэг сурах, шинэ хэл сурах, эсвэл доод ангийнхандаа давтлага өгөх зэрэг ажлуудыг хийж болох юм.

- 2. ACTIVITY гэдэг нь “дипломын хөтөлбөрөөс гадуур бие махбодийн дасгал сургуулалт хийн зөв амьдралын хэв маягт орно.”**

Таны хүүхэд спорт болон бүжгийн арга хэмжээнд оролцох, спортын хандив цуглуулах аянуудыг зохион байгуулах, мөн янз бүрийн сонирхолтой спортуудаар хичээллэх зэрэг орно.

- 3. SERVICE гэдэг нь “сурагчдад ямарваа нэгэн ашиг тус өгөх сайн дурын, үнэ төлбөргүй ажил юм. Эрх үүрэг, нэр төр, бие даасан байдал зэргийг бүгдийг нь хүндэтгэнэ.”**

Харъяа олон нийтийн байгуулгуудтай хамтран байгаль орчин болон туслалцаа хэрэгтэй хүмүүсд тусламжийн гараа сунгах юм. Үүний гол зорилго нь зөвхөн өөрөө бусдад туслах бус бусадтай цуг хамтран ажиллахад оршино.

**Creativity, activity, service –ийн боломж**

Доорхи жагсаалтанд үйл ажиллагаа нь сурагчдад өөрийгөө идэвхитэй байлгах боломжуудыг олгож байна. Хэрэв сурагчид CAS-ын туршилтуудад нь ямар шалгуур үзүүлэлт хэрэгтэй байгааг мэдэхгүй бол CAS-ын зөвлөх багшаас асууж лавлах үүрэгтэй. CAS-ын 3 цөм хэсгийг хангах зарим үйл ажиллагааг доор дурдая.

*Creativity*

- Шатрын дугуйлан
- Хоор дууны дугуйлан
- Мэтгэлзээний клуб
- Сургуулийн сонин
- Хөгжмийн зэмсэг тоглох (заах болон сурах)
- Вэбсайт хөгжүүлэх
- Фотошоп программыг заах

*Activity*

- Бөхийн тэмцээн
- Спорт арга хэмжээнд оролцох
- Алхалтын, гүйлтийн, дугуй уналтын арга хэмжээнд оролцох
- Иогын сургалтанд суух
- Бүх төрлийн бүжгийн сургалт

*Service*

- Орчин тойрноо цэвэрлэх
- Зусланд ашгийн бус сайн дурын ажил хийх зусланд
- Эмнэлэгт сайн дурын ажил хийх
- Номын санд сайн дурын ажил хийх (нийтийн болон сургуулийн)
- Хөгшин настай иргэдэд туслах
- Бага болон дунд ангийн сурагчдад хичээл заах

### **CAS-ын сургалтын долоон үр дүн**

CAS-ын хөтөчөд дурьдсанаар CAS-ын үйл ажиллагаа нь доорхи долоон үр дүнгийн аль нэг гурав нь багтсан байх шаардлагатай. Сурагчид эдгээр долоон үр дүнг сайтар уншин судалж аль нь өөрийн хийх гэж буй төсөлд хамааралтай эсэхийг нягтлана. Дипломын хөтөлбөр хэрэгжих хоёр жилийн хугацаанд суралцагч нь CAS-ын хүрээнд эдгээр долоон үр дүнг бүгдийг нь цуглуулсан байх шаардлагатай. Зарим үр дүн нь өөр өөр төсөл үйл ажиллагаан дээр давхацсан байж болох ч бүх үр дүнгийн ямар нэгэн баримт нотолгоог өөрийн хавтсанд хавсарсан байхыг шаардна. Сурагчид улирлын хагасын болон улирлын эцсийн эргэцүүлэлд ямар үйл ажиллагаа, төсөлд ямар үр дүнг яаж олж авснаа жишээ баримттайгаар бичгэн хэлбэрээр илэрхийлнэ.

CAS-д сургалтын 7 үр дүн байна. Үүнд:

**1. STRENGTHS AND GROWTH.** Өөрийн давуу талыг ухамсарлан, хөгжүүлэх шаардлагатай зүйлээ мэдэж авах

**2. CHALLENGE AND SKILLS.** CAS-ын сургалтын явцад сорилтыг давж, шинэ чадваруудад суралцсан гэдгээ харуулах

**3. INITIATIVE AND PLANNING.** CAS-ийг хэрхэн төлөвлөж явуулж болохыг харуулах

**4. COLLABORATIVE SKILLS.** CAS-ын үйл ажиллагааг зохион явуулах тэвчээр хатуужилбайж амлалтандаа хүрч байгаагаа харуулах

**5. COMMITMENT AND PERSEVERANCE.** Хамтран ажиллахын ач холбогдлыг ойлгож, хамтран ажиллах чадвараа харуулах

**6. GLOBAL ENGAGEMENT.** Дэлхий нийтэд ач холбогдолтой үйл ажиллагааг зохион байгуулж, оролцож байгаагаа харуулах

**7. ETHICS OF CHOICES AND ACTIONS.** Сонголт болон үйл хөдлөлийнхөө үр дагаврыг ухаарах



## CAS-ын ажлын үе шатууд

CAS-ын үйл ажиллагааг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

**1. Ажиглан судлах:** Суралцагчид өөрсдийнхөө сонирхол, авьяас чадвар, хөгжүүлэх шаардлагатай талуудаа танин мэдэх зорилгоор CAS-ын ажлаа сонгон авна. Суралцагчид CAS-ын ажлынхаа зорилго, юу хийхийг хүсч байгаагаа тодорхойлно. Үйлчилгээ /service/-ний хэсэгт хамаарах ажил зохион байгуулахдаа тухайн ажлыг хийх ямар хэрэгцээ байгааг тайлбарлах шаардлагатай.

**2. Бэлдэх:** Суралцагчид CAS үйл ажиллагаа явуулах шаардлагатай бол ямар ч ур чадвар олж авах, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, төлөвлөгөө боловсруулж, тодорхой нөөц, цаг хугацаа тодорхойлох хэрэгтэй.

**3. Үйл ажиллагаа зохиох, гүйцэтгэх:** Суралцагчид шийдвэр гаргах болон асуудал шийдвэрлэх чадвараа ашиглан өөрсдийн санаа эсвэл төлөвлөгөөгөө бие даан, хосоор эсвэл багаар хэрэгжүүлнэ.

**4. Хийсэн зүйлийнхээ талаар эргэцүүлэл бичих:** Суралцагчид юу болсон, юу хийсэн, ямар сэтгэгдэл төрсөн зэргээ дүрслэн бичсэнээр шинэ санаа, асуултууд урган гарна. CAS-ын үйл ажиллагааны аль ч шатанд төлөвлөгөөгөө дахин нягтлах, туршлагаасаа суралцах, хувь хүний хөгжил, ололт амжилт хоёрын хоорондын холбоо, үр дүнг тодорхой болгохын тулд эргэцүүлэмж бичиж болох ба энэ нь шинэ үйл ажиллагааны эхлэхэд ч хүргэж болно.

**5. Баталгаа, нотолгоог үзүүлэх:** Суралцагчид сурсан, хийсэн зүйлүүдээ нотолж харуулна. Жишээ нь: CAS туршлагаа CAS-ын хавтсаараа дамжуулан албан болон албан бус байдлаар бусад суралцагчиддаа үзүүлсэнээр суралцагчид өөрсдийн ойлголтоо бататгах, бусаддаа сэтгэгдэл төрүүлнэ.

## Эргэцүүлэл & Нотолгоо

### Эргэцүүлэлийн бүрэлдэхүүн

“Дүгнэлт бол өөрийгөө танин мэдэх, суралцах болон шийдвэр гаргах цогц арга юм. CAS-ын эргэцүүлэл хэсэгт дөрвөн элемент, бүрэлдэхүүнээс бүрддэг.” (Creativity, activity, service guide, 2017, p.26)

*Эхний хоёр элемент нь эргэцүүллийн суурь хэсэг болдог.*

- Юу болсоныг тайлбарлах: сурагчид дурсамжтай мөчүүдээ тайлагнахдаа юу чухал нөлөөтэй байсан, юу сайхан эсвэл хэцүү байсан, ямар саад бэрхшээл эсвэл амжилт байсан эсэхийг бодох.
- Мэдрэмжээ илэрхийлэх: сурагчид өөрийн туршлагад үндэслэн сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл хийнэ.

*Дараах хоёр элемент нь эргэцүүллийг гүнзгийрүүлж, хэтийн төлөвийг нэмэгдүүлнэ.*

- Үзэл бодлоо илэрхийлэх: сонголт, үйл ажиллагаануудыг эргэн харах буюу дахин шалгаж үзэх нь өөрийгөө болон нөхцөл байдлын талаархи мэдлэгийг нэмэгдүүлнэ
- Асуулт асуух: Хүмүүс, үйл явц, асуудлуудын талаархи асуултууд цаашдын сэтгэлгээг хөгжүүлж асуулгыг цааш үргэлжлүүлнэ.

### Эргэцүүлэлийг гүнзгийрүүлэх

Эргэцүүлэлийн дөрвөн элементийг үр дүнтэй ойлгох үүднээс сурагчид илүү их эрэлхийлэх сэтгэлгээний ур чадварыг бодол санаа, мэдрэмж, үйлдлүүдийг шүүмжлэлтэйгээр шалгаж, суралцах замаараа нэгтгэж чаддаг. Мэдлэгийн онол (ТОК) хичээл нь суралцагсдад сэтгэн бодох чадварыг эзэмшүүлж тэдний сэтгэлгээг төлөвшүүлэх, өргөтгөх боломжийг олгодог. Жишээлбэл, ТОК-г судлах үед тэдний сэтгэл хөдлөл болон хэлийг хэрхэн ашиглах талаар авч үздэг.

Дараахь эргэцүүлэлийг авч үзвэл CAS-ын зохицуулагчийн болон / эсвэл зөвлөхийн дэвшүүлсэн санал нь үр өгөөжтэй бөгөөд шаардлагатай байгаа нь харагдах болно. Санал дэвшүүлэх нь албан бус болон албан ёсны байх ба үүнд хэлэлцүүлгийн, блог дээр саналаа бичих, группээр ярилцах гэх мэт олон янзын хэлбэртэй байдаг.

Сурагчид өөрийн шалгарсан аргаар бусдын ажлийн талаархи санал бодлоо илэрхийлж болно.

### **Эргэцүүлэлийн цаг**

Сурагчид бүх CAS-ын ажил дээрээ эргэцүүлэл бичих шаардлагагүй.

Өөрт хамгийн гүн сэтгэгдэл үлдээсэн CAS-ын ажлынхаа тухай эргэцүүлэл бичнэ. Тус болж мэдэх үр дүнг доор хавсаргалаа.

• Сурагчид эргэцүүлэл бичихдээ CAS-ын ажлын гол гол хэсгийг тусгаж өгнө. Жишээлбэл:

- Нээлт хийсэн хором
- Чадвар эзэмшсэн үе
- Саад бэрхшээлийг даван туулсан үе
- Сэтгэл хөдлөсөн мөч
- Ололт амжилтаа тэмдэглэсэн мөч

• Сурагчид CAS-ын ажлын дунд болон эцэст эргэцүүлэл бичдэг ба эргэцүүлэл бичихдээ CAS-ын ажлын үеэр олж авсан мэдлэг чадвараа тусгахын сацуу дараагийн CAS-ын ажлаа төлөвлөхөд анхаарна.

• Багаараа эргэцүүлэл бичих тохиолдолд сурагчид хамтрагчидтайгаа цуг хийсэн ажлынхаа талаар сайтар ярилцаж зөвлөлдсний эцэст бичнэ.

• Сурагчид CAS-ын ажлуудын дунд болон эцэст эргэцүүлэл бичдэг. Ингэснээр сурагчдын төлөвлөх чадвар, боломж, хүлээлт, өөрийгөө сорих болон хувь хүний өсөлт зэрэг нь нэмэгдэнэ.

### **Эргэцүүллийн хэлбэр**

Эргэцүүллийн тоо томшгүй олон хэлбэр бий. CAS-ын сурагчид нь эргэцүүлэл бичихдээ өөрийгөө хэрхэн илэрхийлэх хэлбэрүүдийг мэддэг байх ба ингэснээр тэд өөрсдийн туршлагыг өөрөө болон бусдад илүү ойлгуулах боломжийг олгодог. Жишээлбэл:

• Сурагч явган аялалд явж буй зургаа аван эргэцүүлэлдээ хавсаргаж болно.

• Хоёр сурагч хүүхдэд тусалсан тухайгаа дуу зохиож болно.

• Өөрийн мэдэрсэн ямарваа нэг мэдрэмжийн талаар шүлэг зохиож болно.

- CAS-ын ажлынхаа тухай богино хэмжээний кино, видео хийж болно.
- Хэсэг сурагчид CAS-ын ажлынхаа тухай ханын самбар гаргаж болно.

Сурагчийн эргэцүүлэл нь цогцолбор, харилцан яриа, шүлэг, комик зурвас, жүжиглэсэн тоглолт, захидал, гэрэл зураг, бүжиг болон бусад хэлбэрээр илэрхийлэгдэж болно. Зарим нэгэн эргэцүүллийг сурагч хүсвэл хувьдаа хадгалж болно. Иймээс сурагчдад ямар эргэцүүллийг өөрсдийн CAS багцад байршуулах талаар шийдвэр гаргахыг зөвлөж байна. Сурагчид CAS-ын долоон үр дүнг биелүүлэхийн тулд эргэцүүлээ нотолгоо байдлаар хавсаргах хэрэгтэй.

### **Эцсийн хугацаа**

CAS-ын бүх шаардлагыг сүүлийн хичээлийн жилийн 4 сарын 1нд CAS-ын координаторт хураалгана.. Хэрэв 4 сарын 1 хичээлийн өдөр биш бол дараагийн хичээлийн өдөр эцсийн өдөр болно. Эцсийн хугацаанаас хойш хураалгасан тохиолдолд IB дипломын хөтөлбөрийг хангаагүйд тооцно.

### **CAS-ын төсөл/үйл ажиллагаа**

CAS-ын төсөл/үйл ажиллагаа болгоны дараа суралцагчид “Шинэ үе” сургуулийн онлайн програмын “Reflections” буюу “Эргэцүүлэл” хэсэгт дараах аргуудаас доод тал нь нэгийг сонгон дүгнэлт, эргэцүүлэмж, нотолгоогоо оруулах ёстой. Үүнд:

1. Зураг (тайлбар бичсэн байх)
2. Тэмдэглэл хөтөлсөн дэвтэр
3. Блог
4. Дүрс бичлэгийг холбоосоор оруулах
5. Вэбсайтад холбоос оруулах
6. Бусад бүтээлч аргаар (CAS-ын зохицуулагчаас зөвшөөрөл авсан байх)

CAS-ын үйл ажиллагааны үргэлжлэх хугацаанд 7 хоногт ядаж 1 удаа нотолгоо оруулсан байх шаардлагатай. Жишээ нь: 8 долоо хоног үргэлжилсэн үйл ажиллагаанд доод тал нь 8 удаа баримтжуулсан нотолгоо оруулсан байх гэх мэт.

Эргэцүүлэл бичихдээ өөртөө болон бусдад үйл ажиллагааныхаа ямар үед / эхэнд, дунд, төгсгөлд/ бичихэд тохиромжтой байгааг харгалзан үзэж дараах асуултуудад хариулж болно.

1. Надад ямар мэдрэмж төрсөн бэ?
2. Би юу ухаарсан бэ?
3. Миний явуулсан үйл ажиллагаа ямархуу байсан бэ?
4. Энэ үйл ажиллагаа надад ямар утга учиртай вэ?
5. Миний явуулсан үйл ажиллагаа ямар үнэ цэнэтэй вэ?
6. Энэхүү үйл ажиллагаанаас би юу сурсан, түүнийгээ хэрхэн илүү өргөн цар хүрээгээр ашиглаж болох вэ?
7. Эргэцүүлэлдээ ёс зүйн асуудлыг авч хэлэлцвэл дараах асуултуудад хариулж болно. Үүнд:
8. Үйлчилгээ гэж юу вэ?
9. Эргэцүүлэлдээ ёс зүйн асуудлыг авч хэлэлцвэл дараах асуултуудад хариулж болно. Үүнд:
10. Үйлчилгээ гэж юу вэ?
11. Өөрийнхөө гэр бүлд үзүүлсэн тусламж яагаад тусламжид тооцогддоггүй вэ?
12. Өөрийн үзүүлсэн үйлчилгээгээрээ би бусдад туслаж, дэмжиж чадаж байна уу?
13. Үйлчилгээ үзүүлж байгаа хүний өмнө би ямар үүрэг хүлээх вэ?
14. Үйлчилгээ үзүүлж буй хүмүүстэй тогтоосон харилцааг би хэрхэн дуусгах вэ?
15. Хэрвээ тусламж үзүүлэх гэж буй хүн тусламж авахыг хүсэхгүй бол яах вэ?

## CAS-ын төслүүд

CAS нь маш сайн боловсруулагдсан, дэс дараатай төсөл бөгөөд сурагчдыг CAS-ын олон талын бүтээлч үйл болон үйлчилгээнд сургадаг. CAS-ын хугацаанд сурагчид хамгийн багадаа нэг хөтөлбөрт хамрагдана.

(Creativity, activity, service guide, 2017, p.24)

CAS нь сурагчдын санаачлагатай байдал, цөхрөлтгүй зан, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах чадваруудыг хөгжүүлдэг. CAS нь сурагчдыг бүлгийн эсвэл бүлгээс илүү өргөн хүрээнд нийгмийн түвшин дэх хамтын үйл ажиллагаанд татан оролцуулдаг. Мөн сурагчдад анхдагч байх, хариуцлагатай байх аль эсвэл CAS-ын нэг хэсэг нь байх боломжуудыг олгодог. Хамтран ажиллах нь сурагч нэг бүрийг өөрсдийн хүсэл сонирхол, авьяас чадврыг таньж мэдэх, илрүүлэх боломжуудыг CAS-ын төлөвлөгөө хэрэгжилтээр бий болгодог. Бүх CAS-ын төслүүд загвар болгосон үе шатуудыг дамжих ба үүгээрээ хэрэгжилтийн тодорхой шаардлагуудыг хангасан эсэхэд хяналт тавина. CAS-ын төслүүд нь түүнийг бүрдүүлж буй аль нэг цогц хэсгээс эсвэл тэдгээрийн 2 болоод 3 хэсгээс бүрдэж болно. Доорх жишээнүүд CAS-тай холбоотой нэмэлт мэдээллийг тоймлон хүргэнэ.

- *Creativity: Сурагчидын баг төлөвлөгөө зохиож түүнийхээ дагуу загвараа бүтээн бүтээл хийнэ.*
- *Activity: Сурагчид ямар нэгэн спортын тэмцээн зохиох эсвэл өөр багуудын эсрэг тэмцээнд оролцоно.*
- *Service: Сурагчид давтлага хичээлийн төлөвлөгөө гарган хэрэгтэй сурагчдад давтлага өгнө.*
- *Creativity, activity, and service: Сурагчид бүжиг дэглэн түүгээрээ дүүргийнхээ тэтгэвэрт гарсан иргэддээ үнэ төлбөргүй тоглолт тоглоно.*

CAS-ын төсөл нь төлөвлөөд дуусах хүртлээ хамгийн багадаа нэг сарын хугацаа шаардана. CAS-ын хугацаанд сурагчид өөрсдийн хийсэн CAS-ын ажлын хүрээнд эргэцүүлэл бичдэг.

**Чиглүүлэх асуултууд**

Дараах асуултуудад хариулснаар CAS-ын нэг хэсэг болоход бэлэн эсэхээ мэдэж авах боломжтой.

1. Энэ туршлага нь намайг шинэ зүйл хийхэд минь туслах уу?

2. Миний хийх гэж байгаа зүйл бодит зүйл мөн үү?

3. Энэ туршлага нь надад болон бусдад ямар үр дүн үзүүлэх вэ?

4. Энэ үйл ажиллагаанд хамрагдсанаар би юу сурах вэ?

5. Энэхүү үйл ажиллагаа нь бусад хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ?

6. Энэ үйл ажиллагааны туршид би юуг сурах вэ?

Миний зөвлөгч хэн байх вэ?

---

CAS-ын гурван цогц хэсгийн алийг нь хамраж байна вэ?

\_\_\_ C \_\_\_ A \_\_\_ S

Энэ төсөл маань CAS-ын ямар үр дүнг өгж байна вэ?

\_\_ 1 \_\_ 2 \_\_ 3 \_\_ 4 \_\_ 5 \_\_ 6 \_\_ 7

**CAS-ын туршлага болон төслүүдийн жишээ**

CAS болон Дипломын хөтөлбөрөөс сурагчид CAS болон Дипломын хөтөлбөрийн хичээлүүдийн холбоог харах болно. Доорхи жишээнээс CAS-ын төсөл нь Дипломын хөтөлбөрийн хичээлүүдтэй хэрхэн холбогдож байгааг харж болно.

	CAS-ын туршлага ба төслүүдийн жишээ	Creativity	Activity	Service
Group 1 (Хэл ба уран зохиол)	Хараагүй хүмүүсд зориулсан сонсдог ном гаргах	*		*
Group 2 (Хэлний мэдлэгийг сайжруулах)	Хэлээ сайжруулахыг хүссэн суралцагчдад зориулсан хичээл оруулах	*		*
Group 3 (Хүн нийгэм)	Ахмадын асрамжын газарт амьдардаг ахмадаас тэдний түүхийг тэмдэглэж авах	*		*
Group 4 (Байгалийн шинжлэх ухаан)	Бага насны сурагчдад одон орон судлалын клуб байгуулах	*	*	*
Group 5 (Математик)	Тухайн газар дахь хандивийн төвд санхүүгийн дэмжлэгийг байнга өгөх			*
Group 6 (Урлаг)	Бүжгийн хичээлд хамрагдах	*	*	

**CAS-ын туршлага ба төслүүдийн нэмэлт жишээ**

Үйл ажиллагаа	C	A	S
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэлж сурахыг заах	*	*	*
Софтболын баг дасгалжуулах	*	*	*
Бага насны сурагчдад гитар тоглохыг заах	*		*
Хүүхдүүдтэй хамт ханын зураг зурах	*	*	*
Choreographing a routine for the marching band	*	*	
Ууланд авиралтын экспедицийг ахлах	*	*	*
Ахмадын асрамжын газарт бүжгийн тоглолт явуулах	*	*	*
Бусад сургуулиудтай хөгжмийн болон урлагийн чадваруудаа солилцох	*		*



**CAS-ын суралцагчийн танилцуулгын хавтас**

CAS-ын бүх суралцагчид -ын 7 үр дүнд хүрсэн эсэхээ нотлохын тулд CAS-ын хавтастай байх хэрэгтэй ба энэхүү хавтас нь суралцагч нь Ай Би-ийн суралцагчийн профайлын 10 шинж чанарыг өөртөө хэрхэн хөгжүүлсэн нь харагдах юм. CAS-ын хавтас нь дараах зүйлсийг агуулсан байна:

1. CAS-ын туршлагын төлөвлөгөө
2. CAS-ын туршлагын бодит эргэцүүлэл
3. Суралцагч нь 7 үр дүнд хүрсэн нотолгоо
4. Суралцагчийн -ын төслийн бичиг баримт

*Миний CAS-ын суралцагчийн хавтас ямар загвартай байх вэ?*

CAS-ын суралцагчийн хавтас нь ямар ч загвартай байж болох ба үүнд вэб блог, хувийн тэмдэглэл, бичлэг, зураг зэрэг багтана.

**CAS дахь эцэг эхчүүдийн үүрэг**

CAS эцэг эх/асран хамгаалагч нарыг дараах байдлаар бусдад хүндэтгэлтэй, хүлээцтэй байх хэрэгтэй. Үүнд:

1. CAS бол IB хөтөлбөрийн чухал хэсэг гэдгийг суралцагчид ойлгуулж, дэмжих
2. Суралцагч хэзээ CAS-ын үйл ажиллагаа зохион байгуулж буйг мэдэж, эргэцүүлэмж бичиж буй эсэхэд хяналт тавих
3. Суралцагчдын сайн сайханы төлөө аливаа асуудалыг хэлэлцэх, зөв шийдэл олоход багш нартай хамтран ажиллах.
4. Асуулт байвал Суралцагчийн CAS-ын зохицуулагч/зөвлөхтэй холбогдож ярилцах
5. Сургуулийн бусад эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтнуудад өөрийн үг, үйл хөдлөлөөр үлгэрлэн манай сургуулийн ёс зүйн хэм хэмжээг дэмжиж
6. Өөрийн хүүхдийг олон нийтийн газарт биеэ зөв, соёлтой авч явах дадалд сургаснаар бусадтай зөрчилдөхөд хүргэхээс сэргийлэх
7. Сургуулиас зохион байгуулж буй эсвэл хичээлээс гадуурх бүхий л үйл ажиллагаанд суралцагчдад үр ашигтай зөвлөгөө өгөх
8. Сургуулийн орчин тойронд хог хаяхгүй байх гэх мэт сургуулийн орчинд хүндэтгэлтэй хандах

**CAS-ын эцэг эхтэй хийх гэрээ**

---

(Эцэг эхийн нэр)

Миний бие “Шинэ үе” сургуулийн CAS-ын гарын авлагыг уншиж танилцаад өөрийн хүүхэд

---

(суралцагчийн нэр)

-ыг CAS-ын үйл ажиллагаанд хамрагдахыг нь зөвшөөрч байна.

1. Миний хүүхэд CAS-ын хянагчын хяналтан дор байхыг нь зөвшөөрч байна.
2. CAS-ын үйл ажиллагаа нь 18 сарын турш үргэлжлэхийг нь ойлгож байна.
3. Хүүхдээ цаашид дэмжиж ажиллах болно.
4. CAS-ын кординатортой ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд уулзаж, зөвлөгөө авна.
5. Шинэ үе сургууль нь ямар нэгэн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй ба харин тусламж, дэмжлэг, заавар зэргийг өгөхийг нь ойлгож байна.
6. Миний хүүхэд “Шинэ үе” сургуулиас санхүүжүүлээгүй ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагдах бол энэ үйл ажиллагаатай холбоотой бүхий л үүрэг хариуцлага, хүүхдийнхээ аюулгүй байдлыг эцэг эхийн зүгээс хариуцна.
7. Сургуулиас гадуурх үйл ажиллагаанд оролцож байхдаа миний хүүхэд ямар нэгэн гэмтэл авсан эсвэл өвдсөн тохиолдолд эцэг эхийн зүгээс анхны тусламжийг үзүүлнэ.
8. Үйл ажиллагаанд хамрагдсаныг нотлох гэрэл зураг авахыг нь зөвшөөрч байна.

Энэхүү гэрээний нөхцөлийг ойлгож, зөвшөөрч байна.

---

Овог нэр

---

Он сар өдөр

---

Гарын үсэг

---

Утас

---

Цахим шуудан